Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 48,504,620.6 мянга, эцсийн үлдэгдэл 2,815,934.1 мянган төгрөг болж 45,688,686.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Баянхонгор сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	<b>44,988,047.2</b>	<b>2,725,107.1</b>	<b>41,432,940.1</b>	<b>100%</b>
Барилга байгууламж, орон сууц	37,765,504.9	1,866,032.0	35,899,472.8	68%
Тээврийн хэрэгсэл	238,871.6	208,135.2	30,736.4	8%
Машин тоног төхөөрөмж	3,386,422.8	359,907.8	3,026,515.0	13%
Тавилга эд хогшил	2,262,506.6	273,658.8	1,988,847.9	10%
Зам гүүрийн байгууламж	-	-	-	0%
Түүх соёлын дурсгалт зүйл	194.7	-	194.7	0%
Номын фонд	246,164.6	473.3	245,691.3	0%
Бусад үндсэн хөрөнгө	258,381.9	16,900.0	241,481.9	1%
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>4,298,518.0</b>	<b>86,452.0</b>	<b>4,212,066.0</b>	<b>95%</b>
Программ хангамж	48,055.4	4,375.0	43,680.4	5%
Бусад биет бус хөрөнгө	4,298,518.0	86,452.0	4,212,066.0	95%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>48,504,820.6</b>	<b>2,815,934.1</b>	<b>45,688,886.5</b>	

Эх сурвалж: Баянхонгор сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 32,549.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 253,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, бусад эх үүсвэрээс 91,311.5 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэн, сумын 9 сургууль, 16 цэцэрлэг, Шаргалжуутын Эрүүл мэндийн төв нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан бүтцийн өөрчлөлтөөр 46,066,067.8 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	91,723.5	100,383.5	(8,660.0)	0%
ЗДТГ	2,009,779.1	2,378,500.4	(368,721.3)	0%
Шаргалжууг тосгон	337,050.1	337,050.1	(0.0)	0%
ЭМТ	1,312,833.2	-	1,312,833.2	0%
1-р сургууль	11,999,463.0	-	11,999,463.0	0%
2-р сургууль	3,397,069.7	-	3,397,069.7	0%
3-р сургууль	4,680,335.4	-	4,680,335.4	0%
Шаргалжууг сургууль	662,103.0	-	662,103.0	0%
Баян-Ойт сургууль	2,287,477.3	-	2,287,477.3	0%
4-р сургууль	2,887,630.0	-	2,887,630.0	0%
Япон сургууль	1,496,625.0	-	1,496,625.0	0%
6-р сургууль	180,567.0	-	180,567.0	0%
1-р цэцэрлэг	1,447,616.0	-	1,447,616.0	0%
2-р цэцэрлэг	606,436.8	-	606,436.8	0%
3-р цэцэрлэг	810,510.9	-	810,510.9	0%
4-р цэцэрлэг	802,299.1	-	802,299.1	0%
5-р цэцэрлэг	1,477,315.2	-	1,477,315.2	0%
6-р цэцэрлэг	1,613,197.8	-	1,613,197.8	0%
7-р цэцэрлэг	711,109.7	-	711,109.7	0%
8-р цэцэрлэг	1,278,008.7	-	1,278,008.7	0%
9-р цэцэрлэг	620,799.0	-	620,799.0	0%
10-р цэцэрлэг	2,188,519.2	-	2,188,519.2	0%
11-р цэцэрлэг	919,786.5	-	919,786.5	0%
12-р цэцэрлэг	596,139.2	-	596,139.2	0%
13-р цэцэрлэг	569,181.9	-	569,181.9	0%
14-р цэцэрлэг	408,420.8	-	408,420.8	0%
15-р цэцэрлэг	876,726.9	-	876,726.9	0%
16-р цэцэрлэг	2,235,896.8	-	2,235,896.8	0%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>48,504,820.6</b>	<b>2,815,934.1</b>	<b>45,688,886.5</b>	<b>0%</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8,132.6 мянга, эцсийн үлдэгдэл 38,479.2 мянган

төгрөг болж 30,346.6 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг Бараа, үйлчилгээний зардлын өглөг	2,254.6	248.4	(2,006.2)	1%
Байгууллагад төлөх өглөг	1,860.9	9.5	(1,851.4)	0%
Хувь хүмүүст төлөх өглөг	3,672.8	38,221.3	34,548.5	99%
Дүн	344.3	-	(344.3)	0%
<b>Дүн</b>	<b>8,132.6</b>	<b>38,479.2</b>	<b>30,346.6</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 248.4 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой, 9.5 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын, 38,221.3 мянган байгууллагад төлөх өглөг байна. Сумын ОНХС-д аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 38,221.3 мянган төгрөг, ЗДТГ-т ажиллагчтай холбоотой өглөг 248.4 мянга, ИТХ-д 9.5 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөгийн үлдэгдэлтэй байна.

**Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	0	9.5	9.5	0%
ЗДТГ	199.7	248.4	48.7	1%
1-р сургууль	1,716.4	-	(1,716.4)	0%
2-р сургууль	39.9	-	(39.9)	0%
2-р цэцэрлэг	635.6	-	(635.6)	0%
3-р цэцэрлэг	132.3	-	(132.3)	0%
5-р цэцэрлэг	85.2	-	(85.2)	0%
7-р цэцэрлэг	284.1	-	(284.1)	0%
8-р цэцэрлэг	63.4	-	(63.4)	0%
10-р цэцэрлэг	254.4	-	(254.4)	0%
14-р цэцэрлэг	89.0	-	(89.0)	0%
Шаргалжуут ЭМГ	4,632.6	-	(4,632.6)	0%
ОНХСан	-	38,221.3	38,221.3	99%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8,132.59</b>	<b>38,479.18</b>	<b>30,346.59</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.4.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 46,196,167.7 мянга, эцсийн үлдэгдэл 4,907,771.5 мянган төгрөг болж, 41,288,396.2 мянган төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,355,674.8	956,190.3	-13,399,484.5	31.1
Өмч: - төрийн	14,355,674.8	956,190.3	-13,399,484.5	31.1
Хуримтлагдсан үр дүн	19,138,938.5	3,584,785.3	-15,554,153.2	41.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,701,554.4	366,795.9	-12,334,758.5	27.5
<b>Дүн</b>	<b>46,196,167.7</b>	<b>4,907,771.5</b>	<b>-41,288,396.2</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,907,771.5 мянган төгрөг болж 41,288,396.2 мянган төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан үндсэн хөрөнгө, бараа материалын дансны

үлдэгдлийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн, мөн шилжүүлсэн үндсэн хөрөнгөтэй холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний 12,334,758.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

### 3.4.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.16-ны өдрийн 4/16 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 7,836,500.0 мянга, хүү торгуулийн орлогыг 30,000.0 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 701,000.0 мянга нийт 8,537,500.0 мянган төгрөгөөр баталжээ. Тодотголоор татварын орлогыг 7,620,414.8 мянга, татварын бус орлогыг 51,400.0 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 709,400.0 мянга нийт 8,329,814.0 мянган төгрөгөөр буюу 207,686.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

Д/д	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Нийт дүн</b>		<b>8,329,814.8</b>	<b>8,684,288.8</b>	<b>354,474.0</b>
<b>Сумд төвлөрөх орлогын дүн</b>		<b>7,569,014.8</b>	<b>8,232,680.3</b>	<b>663,665.5</b>
	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	4,350,984.3	5,026,614.3	675,630.0
1	ИОТХ	830,000.0	906,853.7	76,853.7
2	хадгаламжийн хүүгийн орлого	890,000.0	494,510.5	(395,489.5)
3	ҮХЭХ борлуулсны албан татвар	333,000.0	296,313.3	(36,686.7)
4	Бууны татвар	7,500.0	5,080.0	(2,420.0)
5	Улсын тэмдэгт	20,000.0	47,369.5	27,369.5
6	Газрын төлбөр	126,000.0	87,618.5	(38,381.5)
7	ҮХЭХ-ийн албан татвар	335,000.0	246,725.2	(88,274.8)
8	Ус рашаан	10,000.0	9,872.3	(127.7)
9	Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	568,000.0	658,668.8	90,668.8
10	ТТАМАТөлбөр	5,000.0	2,182.5	(2,817.5)
11	Ан агнуурын орлого	55,000.0	399,542.4	344,542.4
13	Малын хөлийн албан татвар	38,530.5	27,864.0	(10,666.5)
14	Бусад татвар	-	23,465.3	
<b>Татварын бус орлого</b>		<b>760,800.0</b>	<b>451,608.5</b>	<b>(309,191.5)</b>
12	Хүү торгууль	51,400.0	442,181.3	390,781.3
14	Төсөвт байгууллагын өөрийн орлого	709,400.0	9,427.2	(699,972.8)

Татварын орлогын төлөвлөгөө 663,665.5 мянган төгрөгөөр давуулан 8,232,680.0 мянган төгрөг орсон байна. Татварын нэр төрлөөр авч үзвэл цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 675,630.0 мянга, үйл ажиллагааны орлого 76,853.7 мянга, улсын тэмдэгтийн хураамж 27,369.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн.

Татварын мэдээгээр Баянхонгор сумын татварын орлогыг 8,379,220.7 мянган төгрөг буюу 94,570.0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн нь Татварын хэлтэс нь 2023.01.01-ны орлогыг тайлант оны татварын орлогоор, 2022.01.01-ны орлогыг өмнөх оны татварын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнээс шалтгаалсан байна.

Ан агнуурын орлогоор 2 идлэг шонхроос орох орлогыг 55,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр сумын Засаг даргын байгуулсан 10 идлэг шонхор бариулах гэрээний үндсэн дээр 399,542.4 мянган төгрөг орсон байна. Тус ан агнуурын орлогоос 53,561.2 мянган төгрөгийг байгаль орчин нөхөн сэргээх зардалд зарцуулан 245,981.2 мянган төгрөгийг зарцуулаагүй харилцах дансанд үлдэгдлээр байршиж байна.

Татварын ерөнхий газраас ирсэн малчин, мал бүхий өрхийн малын тоо толгойн татвар төлөхөөр үүсгэсэн нэхэмжлэх нь 103,637.5 мянган төгрөг ба Баянхонгор сум нь Шаргалжуут багийн 267 малчин өрх, 46 мал бүхий өрхөөс малын тоо толгойн албан татварыг оруулахаар төлөвлөгөөг 38,530.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Баянхонгор сумын малчид нь аймгийн бүх суманд байдаг бөгөөд мал тооллогоор байгаа сумандаа мал нь тоологддогдоос шалтгаалан малын тоо толгойн албан татвар нь мал тоологдсон суманд орж байгаатай холбогдуулан Татварын ерөнхий газраас ирүүлсэн нэхэмжлэхээр бүрэн оруулах боломжгүй байдал үүссэн байна. Тухайлбал 2022 онд Баянхонгор сумын малчин, мал бүхий иргэдийн малын тоо толгойн албан татвар Бөмбөгөр сумын орон нутгийн төсвийн дансанд орсон байсныг Баянхонгор сумын Малын албан татварын 10032000917 тоот харилцах дансанд төвлөрүүлж авсан байна.

Малын тоо толгойн албан татвар гүйцэтгэлээр 27,864.0 мянган төгрөг оруулж орлогын төлөвлөгөө 10,666.5 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.1.<sup>1</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд малын тоо толгойн албан татварын 2022 онд төлөвлөлтөөс дутуу оруулсан 10,666.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж төсөвт төвлөрүүлэх албан шаардлага, Баянхонгор сумын малын тоо толгойн албан татварыг төлүүлэхээр үүссэн нэхэмжлэх нь тухайн сумын төсөвт бүрэн орох талаар аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлэн малын тоо толгойн албан татварын бодитой төлөвлөж, тайлагнаж байх зөвлөмжийг хүргүүлж байна.

Хадгаламжийн хүүгийн орлого 395,489.6 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 36,686.7 мянга, газрын төлбөр 38,381.5 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 88,274.8 мянган төгрөгөөр тус тус тасарсан байгаа нь хадгаламжийн хүү буурсан, татварыг бүрэн хурааж авах талаар арга хэмжээ аваагүй, төвлөрүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 709,400.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 9,427.2 мянган төгрөг орсон нь төсөвт байгууллагын өөрийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой ба үүнийг хэрхэн оруулах талаар төлөвлөсөн, авсан арга хэмжээ байхгүй байна.

### **3.4.8 Зардлын данс**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 9,552,919.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 8,418,967.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 7,783,650.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 635,317.2 мянган төгрөгийг

---

<sup>1</sup> Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө.

хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 31 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.16-ны өдрийн 4/16 дугаар тогтоолоор нийт 10,709,913.6 мянган төгрөгийг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.16-ны өдрийн 4/16 дугаар тогтоолоор анх 10,709,913.6 мянган төгрөг, сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.30-ны өдрийн 6/36 дугаар тогтоолоор 10,266,529.5 мянган төгрөг болгон 433,384.1 мянган төгрөгөөр бууруулан баталсан.

Эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилт 704,396.8 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 328,814.8 мянга, сумын орон нутгийн татварын болон татварын бус орлого 7,620,414.0 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,059,800.0 мянга, урьд оны үлдэгдлээс 780,402.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.30-ны өдрийн 6/36 дугаар тогтоолоор төсвийн нийт зарлагыг 10,266,529.5 мянган төгрөг болгон 433,384.1 мянган төгрөгөөр бууруулсан нь ОНХС-аас олгох дэмжлэгийг 56,178.0 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 147,600.0 мянга, татварын орлогыг 216,085.2 мянган төгрөгөөр бууруулан аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 328,814.8 мянган төгрөгийг хасаж аймгийн төсөвт 713,609.8 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Сургууль, цэцэрлэгийн гэрээт ажилчдын цалин, НДШ-ийг орон нутгийн төсөвт баталсныг 2022 оны 5 сараас улсын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор 1,140,757.7 мянган төгрөг, сумын ИТХ-ын төсвөөс 74,362.9 мянга, ЗДТГ-ын төсвөөс 16,021.7 мянга, ОНХС-аас 130,966.5 мянган төгрөгөөр бууруулж төсөвт тодотгол хийсэн байна.

А	НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	2021.12.16-ны 4/16 хурлын тогтоолоор	2022.06.30 ны 6/36 хурлын тогтоолоор	Зөрүү
1	Сумын ТЕЗ-ийн нийт орлогын эх үүсвэр	10,709,913.6	10,266,529.5	(443,384.1)
1.1	Татварын орлого	7,836,500.0	7,620,414.8	(216,085.2)
1.2	Хүү торгуулийн орлого			-
1.3	Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	328,814.8	-	(328,814.8)
1.4	Улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлэг	704,396.8	648,218.8	(56,178.0)
1.5	Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг			-
1.6	Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг			-
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,059,800.0	912,200.0	(147,600.0)
1.8	Төсвийн урьд оны үлдэгдэл	780,402.0	1,085,695.9	305,293.9

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 7,052,993.6 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилт 648,218.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 120,828.1 мянга, туслах үйл ажиллагааны орлого 9,427.2 мянга нийт 7,831,248.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,418,967.4 мянган төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь сумын ЗДТГ 728,201.5 мянга, ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг 115,829.9 мянга, Сум хөгжүүлэн сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүйгээс 183,377.7 мянган төгрөгийн хэмнэлт үүссэнээс шалтгаалсан байна.

Төсөвт байгууллагуудын хэмнэсэн тогтмол зардал 134,771.8 мянган төгрөгийг сумын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бх. Бх. Засаг даргын тамгын газар	2,790,965.4	2,062,763.9	728,201.5	73.9
Бх. Бх. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	314,531.0	307,717.3	6,813.7	97.8
Бх. Бх. 1-р сургууль	929,210.3	929,209.5	0.8	100.0
Бх. Бх. 1-р цэцэрлэг	163,725.3	152,004.0	11,721.3	92.8
Бх. Бх. 2-р сургууль	577,324.5	563,952.5	13,372.0	97.7
Бх. Бх. 2-р цэцэрлэг	67,205.3	66,946.5	258.8	99.6
Бх. Бх. 3-р сургууль	565,039.8	562,830.2	2,209.6	99.6
Бх. Бх. 3-р цэцэрлэг	97,242.6	91,984.2	5,258.4	94.6
Бх. Бх. 4-р сургууль	258,990.5	258,409.2	581.3	99.8
Бх. Бх. 4-р цэцэрлэг	71,116.6	68,967.5	2,149.1	97.0
Бх. Бх. 5-р цэцэрлэг	112,108.2	110,989.2	1,119.0	99.0
Бх. Бх. 5-р сургууль	120,627.2	120,445.6	181.6	99.8
Бх. Бх. 6-р сургууль	434,351.4	432,032.3	2,319.1	99.5
Бх. Бх. 6-р цэцэрлэг	108,652.4	101,777.7	6,874.7	93.7
Бх. Бх. 7-р цэцэрлэг	96,113.1	92,381.6	3,731.5	96.1
Бх. Бх. 8-р цэцэрлэг	44,551.5	42,858.1	1,693.4	96.2
Бх. Бх. 9-р цэцэрлэг	62,977.1	61,226.3	1,750.8	97.2
Бх. Бх. 10-р цэцэрлэг	92,780.5	90,392.5	2,388.0	97.4
Бх. Бх. 11-р цэцэрлэг	91,542.2	83,889.1	7,653.1	91.6
Бх. Бх. 12-р цэцэрлэг	74,861.3	64,194.0	10,667.3	85.8
Бх. Бх. 13-р цэцэрлэг	50,162.7	49,773.6	389.1	99.2
Бх. Бх. 14-р цэцэрлэг	42,746.8	40,943.0	1,803.8	95.8
Бх. Бх. 15-р цэцэрлэг	60,392.4	57,644.9	2,747.5	95.5
Бх. Бх. 16-р цэцэрлэг	153,273.7	150,341.2	2,932.5	98.1
Бх. Бх. Баян-ойт сургууль	195,134.8	183,675.9	11,458.9	94.1
Бх. Бх. Сум хөгжүүлэх сан	931,930.4	748,552.7	183,377.7	80.3
Бх. Бх. Шаргалжуут сургууль	70,324.3	69,334.7	989.6	98.6
Бх. Бх. Шаргалжуут тосгон Захирагчийн ажлын алба	53,128.9	50,156.0	2,972.9	94.4
Бх. Бх. Шаргалжуут эмнэлэг	36,698.6	35,639.8	1,058.8	97.1
Бх. Бх. Япон сургууль	134,063.8	132,617.1	1,446.7	98.9
Бх. Бх. Орон нутгийн хөгжлийн сан	751,147.1	635,317.2	115,829.9	84.6
<b>Нийт дүн</b>	<b>9,552,919.7</b>	<b>8,418,967.4</b>	<b>1,133,952.3</b>	<b>88.1</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Баянхонгор сумын ЗДТГ-ын үндсэн үйл ажиллагаанаас олох орлогыг 700,000.0 мянган төгрөгөөр, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 1,418,000.0 мянган төгрөг зарцуулахаар сумын ИТХ-аас баталсан. Гүйцэтгэлээр өөрийн орлого 700,000.0 мянган төгрөг ороогүйтэй холбогдуулан хог хаягдлын хураамжийн зардал 700,000.0 мянган төгрөг хэмнэсэн мэт харагдаж байна.

Мөн сумын татварын орлогод хог хаягдлын хураамжийн орлогыг 568,000.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 658,668.8 мянган төгрөгийн орлого төсөвт төвлөрч,

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-т 718,000.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын төсвөөс /хог хаягдлын хураамжийн зардал/ олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 403,346.5 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ-аас ГХУССЗ-ийн зардал 4,306.6 мянга нийт 407,653.1 мянган төгрөг төвлөрсөн байна.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Шинэ суурьшлын бүсийн хашааны үнэ 366,055.5 мянга, аймгийн ЗДТГ-аас /Сангийн яамны багц/ 11,500.0 мянга, өмнөх оны үлдэгдлээс 13,146.1 мянга, гэрэлтүүлгийн материал, өвсний үнэ 12,600.0 мянган төгрөг төвлөрч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 7. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 05-ний өдөр ирүүлсэн байна.

Баянхонгор сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Г.Энхбаяр, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Д.Оюун-Эрдэнэ нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн

санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,460,337.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 84,603.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 59,222.4 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.03.10-ны өдөр 1/120 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд нийт 90,384.6 мянган зардлыг бууруулан баталж, аймгийн орон нутгийн төсөвт 713,609.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

- Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 328,814.8 мянган төгрөг байсныг 100 хувь хасаж 713,609.7 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн.
- Сумын ЗДТГ-ын төсвөөс 16,021.7 мянган төгрөгөөр, ИТХ-ын төсвийг 74,362.9 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан.
- Сумын ЗДТГ-т жолоочийн орон тоо 1, "Агаар хөрс, орчны бохирдол хариуцсан ажилтан 1, ИТХ-ын жолооч 1 нийт 3 орон тоог хасаж 3 орон тоо хэмнэлт үүссэн байна.

1. Сумын ЗДТГ-ын даргын 2022.01.02-ны 01 дүгээр тушаалаар сумын Засаг даргын орлогч 1 орон тоогоор баталсан.

2. Тээврийн хэрэгсэл: Баянхонгор сумын ИТХ-д Land cruiser 200 маркийн тээврийн хэрэгслийн улсын дугаар 73-24 БНА, СИА маркийн тээврийн хэрэгслийн улсын дугаар 11-89 БНН -тай нийт 58,100.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 суудлын авто машинтай бөгөөд Баянхонгор сумын ИТХ-д байгаа тээврийн хэрэгслийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2<sup>2</sup> дахь заалтыг хэрэгжүүлэх талаар эрх бүхий байгууллагаас тодорхой шийдвэр гараагүй байна.

3. Тайлант онд сумын ИТХ нь тээвэр шатахууны зардалд 10,888.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3 дахь "албан томилолт, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." заалтыг зөрчсөн.

Төсвийн шууд захирагчийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

5. Баянхонгор сумын ЗДТГ-аас өндөр настны тэтгэвэрт 4 албан хаагч гарсан ба төрөөс гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 57,048.1 мянган төгрөгийг зарцуулсан. Байгууллагаас давхардуулан олгосон тэтгэмж байхгүй байна.

6. Орон нутгийн төсвөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.1, 13.13.2, 13.3.2 дахь заалтаар хориглосон хөрөнгө оруулалтын арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

<sup>2</sup> 6.2. Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

7. Баянхонгор сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Сумын Засаг даргын 2022.12.13-ны өдрийн А/291 дүгээр захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Баянхонгор аймаг үүсэж хөгжсөний 80, 81 жилийн ойн арга хэмжээний хүлээн авалтын үйл ажиллагаанд 5,000.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15.1.5<sup>3</sup> дах заалтыг зөрчсөн тул орон нутгийн төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийт 79 мэдээллийн оруулахаас хугацаандаа оруулсан 76 мэдээлэл байна. Тухай бүр тавих мэдээлэл дээр бонд, зээл, өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төрийн хувийн хэвшлийн, түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр дээр 1 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна. Бүтэн жил дээр тавих мэдээлэл дээр Санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан тус тус хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### **4.5 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Баянхонгор сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 53,497.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4,854.6 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж 48,651.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлсэн. Хэрэгжилтийг 2022.07.18-ны өдрийн 2/311 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

#### **4.7 Аудитын гол асуудал**

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

---

<sup>3</sup> төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

Баянхонгор сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба Шаргалжуут тосгоны ЭМТ-1, 9 сургууль, 16 цэцэрлэгийн орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 226,329.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 55,441.3 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 23,457.8 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 6,651.2 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 165,886.6 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Баянхонгор сумын ОНХС-ийн аудитаар Баянхонгор сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.16-ны өдрийн 4/16 тогтоолоор сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн талбайн болон орон сууцуудын орчинд ангилан ялгах хог хаягдлын сав, цэгийн тоог нэмэх 1 ажилд 190.0 сая төгрөг баталсныг сумын ИТХ-ын 2022.06.30-ны өдрийн 6/36 дугаар хуралдааны тогтоолоор багийн нийтийн эзэмшлийн 5 байршилд 15-20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажил болгон нийт 95.0 сая, гэрэлтүүлгийн ажлыг 20.0 сая төгрөгөөр 3 ажил болгон нийт 60.0 сая төгрөгийг баталж шууд гэрээ байгуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.5."Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна. Иймд Баянхонгор сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь хэсэгт мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчаар илэрсэн материаллаг зөрчлийн дүн 45,658.5 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлийн материаллаг байдлын тогтоосон 59,222.4 мянган төгрөгөөс бага байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

/МЯНГАН ТӨГРӨГ/

№	Байгууллага нэгжийн нэр	Аудитын төрөл	Алдаа зөрчлийн ангилал								Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн	
			Аудитаар өгсөн зөвлөмж		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга		Тоо	Дүн /төг/
			Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/		
1	Баянхонгор сумын ЗДТГ	Санхүү	1	11,099.5	2	6,651.2	1	6,686.4			4.00	24,437.1
		Нийцэл					1	5,000.0			1.00	5,000.0
2	Баянхонгор сумын ИТХ	Санхүү	2	9,450.0	0	-	1	186.4			3.00	9,636.4
		Нийцэл	2	10,888.6	0	-	0	-	0	-	2.00	10,888.6
3	Баянхонгор сумын Орон нутаг хөгжлийн сан	Санхүү	1	-	0	-	2	1,110.0	1	38,221.3	4.00	39,331.3
		Нийцэл	2	155,000.0				-			2.00	155,000.0
4	Баянхонгор сумын Сум хөгжүүлэх сан	Санхүү			0	-	1	10,475.0	1	17,220.0	2.00	27,695.0
		Нийцэл	0	-	0	-	0	-	0	-	-	-
	Нийт	Санхүү	4	20,549.5	2	6,651.2	5	18,457.8	2	55,441.3	13	101,099.8
		Нийцэл	4	165,888.6	0	-	1	5,000.0	0	-	5	170,888.6
		Дүн	8	186,438.1	2	6,651.2	6	23,457.8	2	55,441.3	18	271,988.4
Материаллаг алдааны дүн			4	20,549.5	2	6,651.2	5	18,457.8			11.00	45,658.5
Материаллаг бус алдааны дүн			4	165,888.6			1	5,000.0	2	55,441.3	7.00	226,329.9

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 775,774.0 мянган төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрснээс, зөрчил арилгах 10,666.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, зөрчил давтан гаргахгүй байх 765,107.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

#### 5.1.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

1. *Илрүүлэлт.* Баянхонгор сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 226,329.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 55,441.3 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 23,457.8 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 6,651.2 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 165,886.6 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь хэсэгт мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

#### 5.1.2 Татварын орлоготой холбоотой асуудал

2. *Илрүүлэлт:* Баянхонгор суманд бүртгэлтэй малчдын мал нь аймгийн бүх суманд харьяалагдаж, малын тоо толгойн албан татвар нь мал тоологдсон суманд орж байгаатай холбогдуулан Татварын ерөнхий газраас ирүүлсэн 103,637.5 мянган төгрөгийн нэхэмжлэхээр (татварын ногдуулалт) бүрэн оруулах боломжгүй байна. (Тухайлбал тайлант онд Бөмбөгөр сумын орон нутгийн төсвийн дансанд орсон 6,021.5 мянган төгрөгийн малын тоо толгойн албан татварын орлогыг залруулан орлогыг татан төвлөрүүлсэн байна.)

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.1 .Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Баянхонгор сумын малын тоо толгойн албан татварыг төлүүлэхээр үүссэн нэхэмжлэх 103,637.5 сая төгрөгөөс сумын ИТХ-аар 38,530.0 мянган төгрөгөөр баталж 65,10.5 мянган төгрөгийн малын тоо толгойн албан татварыг төлүүлэх боломж алдсан байна. Иймд малын тоо толгойн албан татварыг тухайн сумын төсөвт бүрэн орох талаар аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлэн малын тоо толгойн албан татварын бодитой төлөвлөж, тайлагнаж байх зөвлөмжийг хүргүүлэх.

3: *Илрүүлэлт:* Сумын ИТХ-аар хог тээврийн орлогыг 568,000. мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 700,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж сумын ЗДТГ-ын төсөвт хог хаягдлын зардлыг 1,418,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 658,668.8 мянган төгрөгийн орлого орж, 718,000.0 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.8 дугаар заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн зарчим”, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлого, зарлагыг төлөвлөлтийн үндэслэлтэй төлөвлөж, зарцуулах.

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад жилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

Малын тоо толгойн албан татварыг сумын ИТХ-аар 38,530.0 мянган төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 27,864.0 мянган төгрөг оруулж орлогын төлөвлөгөө 10,666.5 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.1 дэх заалтыг зөрчсөн байна. “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилган, малын тоо толгойн албан татварын орлогыг төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 09 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Малын тоо толгойн албан татварыг сумын ИТХ-аар 38,530.0 мянган төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 27,864.0 мянган төгрөг оруулж орлогын төлөвлөгөө 10,666.5 мянган төгрөгөөр тасарсан байна	1	10,666.5			1	10,666.5							
Баянхонгор суманд бүртгэлтэй малчдын мал нь аймгийн бүх суманд харьяалагдаж, малын тоо толгойн албан татвар нь мал тоологдсон суманд орж байгаатай холбогдуулан Татварын ерөнхий газраас ирүүлсэн 103,637.5 мянган төгрөгийн нэхэмжлэхээр (татварын ногдуулалт) бүрэн оруулах боломжгүй байна	1	65,107.5					1	65,107.5					
Сумын ИТХ-аар хог тээврийн орлогыг 568,000.0 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 700,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж сумын ЗДТГ-ын төсөвт хог хаягдлын зардлыг 1,418,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 658,668.8 мянган төгрөгийн орлого орж, 718,000.0 мянган төгрөгийн зардал гарсан байна	1	700,000.0					1	700,000.0					
Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 226,329.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 55,441.3 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 23,457.8 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 6,651.2 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 165,886.6 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн	1	0					1	0					
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>775,774.0</b>			<b>1</b>	<b>10,666.5</b>	<b>3</b>	<b>765,107.5</b>					

---oOo---